



5120

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 16 сарын 08 өдөр

Дугаар Я1565

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай 24 дүгээр зүйлийн 2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчт төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, орон нутгийн өмчт нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журмыг нэгдүгээр, Даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагыг төлөөлсөн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах ярилцлагын асуултыг хоёрдугаар, Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг төлөөлсөн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах ярилцлагын асуултыг гуравдугаар, Эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийг төлөөлсөн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах ярилцлагын асуултыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн өмчийт төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах сонгон шалгаруулах хороог байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчтэй нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах сонгон шалгаруулах хороог аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газартай байгуулж ажиллахыг Аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/189, А/209 дүгээр тушаалтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙТ

Бүртгэлийн дугаар ... 13

МОНГОЛ УЛСЫН
ЗРҮҮЛ МЭНДИЙН ЯАГ..

ХҮУЛБАР ҮНЭН

Т.МОНХСАЙХАН

2021 02 сарын 26' ний одор

141202254

ТӨРИЙН ӨМЧИТ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД АЖИЛЛАХ ОЛОН
НИЙТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭН СОНГОХ ХУРЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, орон нутгийн өмчит нэгдсэн
эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн
сонгох хурлыг зохион байгуулахад энэхүү журмыг баримтлан нээлттэй сонгон
шалгаруулна.

1.2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хороог (цаашид хороо гэх)
Эрүүл мэндийн яам болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэд
байгуулна.

1.2.1. Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Төлөөлөн
удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгон шалгаруулах
хороог Сангийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, тухайн эмнэлэг, аймаг,
нийслэлийн Эрүүл мэндийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус бүр нэг,
Эрүүл мэндийн яамнаас хоёр, нийт долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

1.2.2. Орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгон шалгаруулах хороог
тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн даатгалын
байгууллага, тухайн эмнэлгээс тус бүр нэг, Эрүүл мэндийн газраас хоёр, Иргэдийн
төлөөлөгчдийн хурлаас хоёр, нийт долоон хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

1.3. Хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.3.1. Нээлтэй сонгон шалгаруулалтыг зарлаж, баримт бичгийг хүлээн
авч, хянах нэгтгэх;

1.3.2. Сонгон шалгаруулалт явуулах байр, бусад шаардагдах нөхцөлийг
хангах;

1.3.3. Урьдчилсан сонгон шалгаруулалт зарлах;

1.3.4. Урьдчилсан сонгон шалгаруулалтаар босго оноо давсан нэр
дэвшигчийн жагсаалт гаргах;

1.3.5. Нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах;

1.3.6. Сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд мэдээлэх;

1.3.7. Сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлланг тэнцсэн нэр дэвшигчийн нэрийн хамт эрх бүхий этгээдэд баталгаажуулахаар хүргүүлэх.

Хоёр. Сонгон шалгаруулалтыг зарлах, баримт бичиг хүлээн авах, урьдчилсан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

2.1. Хороо нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг баримт бичиг хүлээн авахаас 15 хоногийн өмнө Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23-д заасан байгууллагын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлана.

2.2. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.26, 15.27 дахь хэсгүүдийг баримтлан төрийн бус байгууллага нэр дэвшигч гишүүний холбогдох баримт бичгийг заасан хугацаанд багтаан Хороонд ирүүлнэ.

2.3. Төрийн бус байгууллагаас нэр дэвшигч нь Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15.1, 15.26-д тус заасан шалгуурыг хангасныг нотлох дараах баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

2.3.1 нийтийн албанда томилогодохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг;

2.3.2 боловсролын диплом, гэрчилгээ, үнэмлэхний хуулбар, мэргэшлийн зэргийн үнэмлэх эсхүл мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан диплом, гэрчилгээ, үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

2.3.3 улс төрийн намын удирдах, орон тооны болон сонгуульт ажил эрхэлдэггүйгээ баталгаажуулж бичсэн баталгаа;

2.3.4 хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчийн талаарх лавлагаа;

2.3.5 нэр дэвшүүлж буй Төрийн бус байгууллагаас сүүлийн 6 сард нийгмийн даатгалын шимтгэл төлсөн талаарх Нийгмийн даатгалын байгууллагын эсхүл холбогдох татвар төлсөн талаарх Татварын байгууллагын эсхүл үйл ажиллагааны тайланг өгсөн талаарх Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын лавлагаа;

2.3.6 нэр дэвшүүлж буй Төрийн бус байгууллага нь санхүүгийн зөрчилгүй болохыг нотолсон Аудитын байгууллагын тодорхойлолт.

2.4 Хороо сонгон шалгаруулалтын баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан нэр дэвшигчийн баримт бичигтэй танилцаж, хянана.

2.5. Хороо урьдчилсан сонгон шалгаруулалтыг энэ тушаалын хавсралтад дурдсан асуултын дагуу нэр дэвшигчидтэй ярилцлага хийх хэлбэрээр зохион байгуулах бөгөөд нэр дэвшигч бүрээр оноо өгч, хорооны гишүүдийн өгсөн онооны дунджаар 60-аас дээш оноо авсан нэр дэвшигчдийн жагсаалтыг нэр дэвшүүлж сонгон, хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоно.

Гурав. Нэр дэвшиүүлэн сонгох хурлыг зохион өвлийн уулзарал, нэр дэвшигчийн төлөөллийн талаарх мэдээллийг олон нийтэд зарлана.

3.1. Хороо хурлын товыг энэ журмын 2.5-д заасан жагсаалтад багтсан нэр дэвшигчийг дэвшиүүлсэн төрийн бус байгууллагуудад хурал болохоос 14 хоногийн өмнө хүргүүлж, хурлын талаарх мэдээллийг олон нийтэд зарлана.

3.2. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24-т заасан төлөөллийг оролцуулан тухайн эмнэлгийн олон нийтийн 3 төлөөллийг сонгох хурлыг тус тусад нь зохион байгуулна.

3.3. Хурлын тэргүүлэгчдийг энэ журмын 3.8-д заасан оролцогчдоос нээлттэй санал хурааж сонгоно.

3.4. Хурлын тэргүүлэгчид хурлын дэгийг танилцуулж, оролцогчдоор батлуулна.

3.5. Хурлын тэргүүлэгчид олон нийтийн төлөөлөлд нэр дэвшигчийг танилцуулна.

3.6. Хуралд оролцогчид олон нийтийн төлөөлөлд нэр дэвшигчээс нээлттэй асуулт (энэхүү тушаалын хавсралтад зааснаас бусад) асууж, хариулт авна.

3.7 Хурлын тэргүүлэгчид нэр дэвшигч бүрээр нээлттэй санал хураалт явуулна.

3.8. Санал хураалтад Хорооны гишүүд, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15.27-д заасны дагуу нэр дэвшиүүлэн оролцож буй төрийн бус байгууллагын төлөөлөл оролцено.

3.9. Олонхийн санал авсан нэг нэр дэвшигчийг, эсхүл нэр дэвшигчийн аль нь ч олонхийн санал аваагүй бол санал тэнцсэн буюу хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигчийг 2 дахь санал хураалтад оруулж, олонхийн санал авсан 1 нэр дэвшигчийн нэрийг Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 15.30-д заасан эрх бүхий этгээдэд хурлын тэргүүлэгчдийн гарын үсэг бүхий хурлын тэмдэглэлийн хамт баталгаажуулахаар 24 цагийн дотор хүргүүлнэ.

**ДААТГУУЛАГЧИЙН ОЛОНХИЙН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ
СОНИРХЛЫГ ХАМГААЛСАН БАЙГУУЛАГЫГ ТӨЛӨӨЛСӨН ОЛОН НИЙТИЙН
ТӨЛӨӨЛЛИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ**

д/д	Үнэлгээний оноо: 1 (хамгийн сул, муу хариулт), 10 (хамгийн сайн хариулт) Асуултууд	оноо
1	Даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллага эмнэлгийн үйл ажиллагаанд хэрхэн оролцох ёстой тэж боддог вэ?	443
2	Эмнэлгийн гүйцэтгэлийг үнэхэлэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	
3	Эмнэлгийн даргын ажлыг үнэлэхэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	
4	Эмнэлгийн удирдах зөвлөл санхүүгийн талаар шийдвэр гаргахад санхүүгийн ямар мэдээлэл шаардлагатай вэ?	
5	Таны өөрийн санхүүгийн мэдлэг хэр вэ?	
6	Эмнэлгийн удирдах зөвлөлийн бусад гишүүд болон эмнэлгийн даргатай үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна вэ?	
7	Эмнэлгийн ажиллагсад болон эмч настай хамгийн үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна вэ?	
8	Эмнэлгийг үр дүнтэй ажиллуулахад анхаарах гол асуудлууд юунд оршдог вэ? Жишээ баримтаар тайлбарлана уу.	
9	Эмнэлэг олон нийтэд хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэхэд таны зүгээс олон нийтийн санаа бодлыг хэрхэн тусгаж ажиллах вэ?	
10	Эмнэлгийн удирдах зөвлөл орохоор бол эмнэлгийн удирдлагын талаарх сургалтад хамрагдах цаг хугацаа гаргаж чадах уу?	
	НИЙТ	

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛСӨН ОЛОН НИЙТИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ**

д/д	Үнэлгээний оноо: 1 (хамгийн сул, муу хариулт), 10 (хамгийн сайн хариулт) Асуултууд	оноо
1	Эмнэлгийн гүйцэтгэлийг үнэлэхэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	1118270972, 8087443
2	Эмнэлгийн даргын ажлыг үнэлэхэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	
3	Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн талаар шийдвэр гаргахад санхүүгийн ямар мэдээлэл шаардлагатай вэ?	
4	Эмнэлгийн удирдах зөвлөлийн бусад гишүүд болон эмнэлгийн даргатай үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна гэж үзэж байна вэ?	
5	Эмнэлгийн ажиллагсад болон эмч нартай хамгийн үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна вэ?	
6	Эмнэлгийг үр дүнтэй ажиллуулах ямар жишээг дурдаж чадах вэ?	
7	Эмнэлэг олон нийтэд хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлэх талаас таны зүгээс олон нийтийн санаа бодлыг хэрхэн тусгаж ажиллах вэ?	
8	Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл ба эмнэлгийн хамт олны хооронд хэрхэн үр дүнтэй харилцааг бий болгож ажиллах вэ?	
9	Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд орохоор бол эмнэлгийн удирдлагын талаарх сургалтад хамрагдах цаг хугацаа гаргаж чадах уу?	
	НИЙТ	

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭРГЭЖЛИЙН НИЙГЭМЛЭГ, ХОЛБОО,
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙГ ТӨЛӨӨЛСӨН ОЛОН НИЙТИЙН
ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

д/д	Үнэлгээний оноо: 1 (хамгийн сул, муу хариулт), 10 (хамгийн сайн хариулт) Асуултууд	оноо
1	Эмнэлгийн мэргэжилтнүүдийг төлөөлсөн байгууллага эмнэлгийн үйл ажиллагаанд хэрхэн оролцох ёстой гэж боддог вэ? Олон улсын ямар жишээ мэдэх вэ?	
2	Эмнэлгийн гүйцэтгэлийг үнэлэхэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	
3	Эмнэлгийн даргын ажлыг үнэлэхэд ямар асуудлууд хамгийн чухал вэ?	
4	Эмнэлгийн удирдах зөвлөл санхүүгийн талаар шийдвэр гаргахад санхүүгийн ямар мэдээлэл шаардлагатай вэ?	
5	Эмнэлгийн удирдах зөвлөлийн бусад гишүүд болон эмнэлгийн даргатай үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна вэ?	
6	Эмнэлгийн ажиллагсад болон эмч нартай хамгийн үр дүнтэй хамтран ажиллах ямар аргууд байна вэ?	
7	Эмнэлгийг үр дүнтэй ажиллуулах ямар жишээ хэлж чадах вэ?	
8	Эмнэлэг олон нийтэд хүртээмжтэй тусламж үйлчилгээ үзүүлэхэд таны зүгээс олон нийтийн санаа бодлыг хэрхэн тусгаж ажиллах вэ?	
9	Эмнэлгийн удирдах зөвлөл ба эмнэлгийн хамт олны хооронд хэрхэн үр дүнтэй харилцааг бий болгож ажиллах вэ?	
10	Эмнэлгийн удирдах зөвлөлд орохоор бол эмнэлгийн удирдлагын талаарх сургалтад хамрагдах цаг хугацаа гаргаж чадах уу?	
	НИЙТ	